

Тойрог дээрх цэгүүд

L урттай тойрог дээр n тооны ялгаатай цэгүүд өгөгдөв.

Эдгээр цэгүүдийн гурав дээр нь оройтой, тойргийн төвийг дотроо эсвэл ирмэг дээрээ агуулсан байх гурвалжнуудын тоог ол.

Оролт

Эхний мөрөнд n ба L бүхэл тоонууд өгөгдөнө ($n < L$).

Тойргийн дурын цэгийг сонгон авч түүнийг S гэж тэмдэглэе. Тэгвэл тойргийн дурын A цэгийг цагийн зүүний дагуу тойргоор S -ээс A хүртлэх зайг илэрхийлэх x гэсэн ганц тоогоор илэрхийлж болно ($0 \leq x < L$). Уг тоог A цэгийн координат гэж нэрлэе.

Хоёр дахь мөрөнд k гэсэн ялгаатай n ширхэг тоо өгөгдөх ба эдгээр нь тойрог дээр өгөгдсөн цэгүүдийг координат болно.

Гаралт

Өгөгдсөн цэгүүдийн гурав дээр нь оройтой, тойргийн төвийг дотроо эсвэл ирмэг дээрээ агуулсан байх гурвалжнуудын тоог илэрхийлэх ганц бүхэл тоог гаргана.

Жишээ

оролт	гаралт
3 5	0
1 2 0	
3 3	1
0 2 1	